

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2013 оны 01 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар
хот

Заавар батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 18 дугаар зүйлийн 18.1.2, 20 дугаар зүйлийн 20.1, 24 дүгээр зүйлийн 24.1.6 дахь заалт, 19 дүгээр зүйлд заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Мал, амьтны гоц халдварт өвчний голомтод хээрийн мал эмнэлэг дэлгэн ажиллах заавар”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. “Мал, амьтны гоц халдварт өвчний голомтод хээрийн мал эмнэлэг дэлгэн ажиллах заавар”-ыг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Шадар сайд

Д.ТЭРБИШДАГВА

МАЛ, АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГОЛОМТОД
ХЭЭРИЙН МАЛ ЭМНЭЛЭГ ДЭЛГЭН АЖИЛЛАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэрт гарсан олон улсын худалдааны хорио цээрт мал, амьтны гоц халдварт өвчний голомтод үүрэг гүйцэтгэхээр томилогдсон бие бүрэлдэхүүн “Мал, амьтны гоц халдварт өвчний голомтод хээрийн мал эмнэлэг дэлгэн ажиллах заавар”- ыг удирдлага болгон ажиллана.

1.2. Хээрийн мал эмнэлэг нь гоц халдварт өвчнөөр өвчилсөн малын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг шуурхай зохион байгуулж, халдварын тархалтыг таслан зогсоож иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн заавар, зөвлөмж өгч ажиллана.

1.3. Өвчний цагийн байдал, халдварын тархалтын явцаас хамаарч хээрийн мал эмнэлгийн бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөж болно.

1.4. Хорио цээрийн дэглэмийн хугацаанд үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүний томилолт, зориудаар устгасан мал, тэжээвэр амьтдын нөхөн олговор, үйл ажиллагааны зардлыг холбогдох хууль эрх зүйг үндэслэн Засгийн газрын нөөц хөрөнгөнөөс гаргаж олгоно.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Хээрийн мал эмнэлгийг аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар /албаны/- ны дарга ахлана.

2.2. Хээрийн мал эмнэлэг нь “Шуурхай бүлэг”-ийн шууд удирдлагад ажиллана.

2.3. Хээрийн мал эмнэлэг нь Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, бусад хууль тогтоомжийг үндэслэн Засгийн газрын тогтоол, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоох, цуцлах хүртлэх хугацаандүүрэг гүйцэтгэнэ.

2.4. Хээрийн мал эмнэлэг нь удирдлагын, нарийн мэргэжлийн, устгалын, шалган нэвтрүүлэх, халдваргүйтгэлийн бүлгээс бүрдэнэ.

2.5. Дээрх бүлгийн үүрэг гүйцэтгэх нөхцөл боломжийг хангах/стандартаар батлагдсан загвар бүхий/ гэр сууц,халдваргүйтгэлийн байр, багаж тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлтэй байна.

2.6. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамжаар халдварын голомтод үүрэг гүйцэтгэх хээрийн мал эмнэлгийг байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон /газар хөдлөлт, хөрсний гулсалт, зуд, хүчтэй цасан болон шороон шуурга, үер ус/-оос бусад үед 24-36 цагт багтаан дэлгэж үүрэгт ажлыг эхлүүлнэ.

2.7. Хээрийн мал эмнэлэг ньүүрэг гүйцэтгэж байгаахүн, тээврийн хэрэгсэл тухайн сум, дүүргийн болон халдварын голомтод байгаахүн ам, мал сүрэг, тэжээвэр амьтдын судалгаа, өвчилсөн мал, тэжээвэр амьтдыг устгаж, сэг зэмийг булшилсан газрын байршил, цагийн байдлын тухай мэдээллийг хавсралтаар гаргаж шуурхай бүлэгт хүргүүлнэ.

Гурав. Хээрийн мал эмнэлгийн гүйцэтгэх чиг үүрэг

3.1. Хээрийн мал эмнэлэг нь мал, амьтны гоц халдварт өвчний халдварын голомтод үүрэг гүйцэтгэх явуулын лабораторид түргэвчилсэн аргаар оношлогоо хийж, үүссэн цагийн байдалд дүн шинжилгээ хийх, халдварын голомт дахь хүн, мал, тэжээвэр амьтдын судалгааг нарийвчлан гаргаждараах ажил үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

-өвчлөмтгий мал, тэжээвэр амьтан нэг бүрийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах;

-өвчтэйг эрүүлээс тусгаарлан зааврын дагуу устгах;

-эрүүл мал, тэжээвэр амьтанд халдвараас урьдчилан сэргийлэх вакцин тарих;

-малчинд мал, тэжээвэр амьтдыг байнгын хариулага маллагаатай байлгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

-малчдын гэр орон, эд хогшил, малын тоног хэрэгсэл, хашаа хороо, өтөг бууц, уст цэг, газрын хөрсний өнгөн хэсгийг халдваргүйтгэх, өвчилсөн малын тэжээл бусад хог хаягдлыг устгах цэгийг тогтоох;

-хязгаарлалт, хорио цээрийн бүсэд ажиллах хугацаанд хэрэглэхээр худалдан авсан багаж, тоног төхөөрөмж, бусад бараа материал, ажиллагсдын томилолт, хөдөлмөр хамгаалалын хувцас, эм, биобэлдмэл, зүү тариур, халдваргүйтгэлийн бодис, тээврийн хэрэгслийн шатахтослох материалын тооцоог гаргаж орон нутгийн аудитын байгууллагаар шалгуулж баталгаажуулах;

3.2. Мал, амьтны гоц халдвартөвчний халдварын голомт дахь өвчлөмтгий мал, тэжээвэр амьтны судалгаа, байршлын зураглалыг гаргаж эрүүл мэндийн үзлэгт

хамруулах, өвчтэй, сэжигтэй мал, амьтныг эрүүлээс тусгаарлаж, лабораторийн шинжилгээндээж авч онош тогтоох.

3.3.Өвчтэй мал байсан хашаа, хороо, тоног хэрэгсэл, тэжээлийн үлдэгдэл, өтөг бууц, малын сэг, зэмбулшилсан газрын хөрсний өнгөн хэсгийнхалдваргүйтгэлийг зааврын дагуу хийх.

3.4. Халдварын голомтоос эрүүл мэнд, ар гэрийн гачигдлаар гарах зорчигчдыг бүртгэж, биеийн ил хэсэг, тээш, тээврийн хэрэгслийн зорчих хэсгийн гадна тал, явах эд анги,тэвшийг халдваргүйтгэж, бүртгэх.

Дөрөв. Удирдлагын бүлгийн үүрэг

Удирдлагын бүлэг дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

4.1. Халдварын голомтоддэлгэсэн хээрийн мал эмнэлэгт үүрэг гүйцэтгэх томилгоот бие бүрэлдэхүүнийг шуурай удирдлагаар хангаж, төрийн захиргааны байгууллага, иргэдийг бодит мэдээ, мэдээллээр хангах;

4.2. Халдварын голомтод хэрэглэх халдваргүйтгэлийн бодис уусмал, нэн шаардлагатай эм тариаг захиалан авах, нөөцлөх;

4.3. Халдварын голомтод ажиллах хугацаанд зарцуулсан эм тариа, халдваргүйтгэлийн бодис, хөдөлмөр хамгааллын хувцас, бусад бараа материалын зарцуулалтын тайлан, мэдээ гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргэх;

4.4. Өвчний халдвартай нь үзлэг, шинжилгээгээр тогтоогдсон мал, тэжээвэр амьтдыг зориудаар устгах аргачлалаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавих;

4.5. Зориудаар устгасан мал, тэжээвэр амьтдыг устгасан тухай акт баримт бичгийг зааврын дагуу бүрдүүлэн албажуулсан байх;

4.6. Халдварын голомтод гүйцэтгэсэн ажлын нэгдсэн тайлан, мэдээг ажлын 20 хоногт багтаан гаргах.

Тав. Нарийн мэргэжлийн бүлгийн үүрэг

Нарийн мэргэжлийн бүлэг дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

5.1. Гоц халдварт өвчин гарсан бүс нутаг дахь мал, тэжээвэр амьтанд эрүүл мэндийн үзлэг хийж өвчилсөн мал, тэжээвэр амьтдаас авсан дээжийг Зам, тээвэр аялал жуучлалын сайдын 2006 оны 70 дугаар тушаалаар батлагдсан “Биоаюултай илгээмж, биобэлдмэлийг тээвэрлэх журам”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2010 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Мал эмнэлгийн лабораторийн шинжилгээнд зориулсан дээж авах, бэлтгэх, илгээх журам”-ын дагуу аймаг, нийслэл дэх Малэмнэлэг, ариун цэврийн лабораторид хүргэж шинжилгээ хийлгэх;

5.2. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн мал, тэжээвэр амьтныг бүртгэж, арчилгаа маллагааг тусгай горимд шилжүүлэн байнгын хяналт тавих;

5.3. Өвчний ил шинж тэмдэгтэй мал, тэжээвэр амьтныг эрүүлээс тусгаарлан тухайн өвчинтэйтэмцэх зааврын дагуу зориудаар устгасан тухай актыг 5 хувь үйлдэж баталгаажуулах;

5.4. Голомт дахь эрүүл мал, тэжээвэр амьтныг нэг бүрчлэн эрүүл мэндийн үзлэгт хамруулах, өвчин гарсан хот айлын малын хашаа хороо, өтөг бууц, тоног хэрэгслийг халдваргүйтгэх.

Зургаа. Устгалын бүлгийн үүрэг

Устгалын бүлэг дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

6.1. Гоц халдварт өвчний ил шинж тэмдэгтэй, лабораторийн шинжилгээгээр гоц халдвартөвчнөөр өвчилсөн болох нь батлагдсан мал, тэжээвэр амьтдыг холбогдох мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2010 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Мал, амьтныг зориуд устгах, булшлах үйл ажиллагааны заавар”-ын дагуу нядлах, устгах ажлыг гүйцэтгэх;

6.2. “Мал, амьтныг зориуд устгах, булшлах үйл ажиллагааны заавар”-ын дагуу устгалын нүх бэлтгэж, газрыннэр, байршлын солбилцолыг тэмдэглэн авч, анхааруулга, тэмдэглэгээ байрлуулжнутгийн захиргааны байгууллага /мэргэжлийн хяналт, байгаль орчны хяналт/-д хүлээлгэн өгөх.

Долоо.Шалган нэвтрүүлэх, халдваргүйтгэх бүлгийн үүрэг

Шалган нэвтрүүлэх, халдваргүйтгэх бүлэг дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

7.1. Халдварын голомтод ажиллагсадшалган нэвтрүүлэх цэгт хүрэлцэн ирсэн зорчигчдын зөвшөөрлийн баримт бичгийг үндэслэн бүртгэж хувцас, тээш, тээврийн хэрэгслийг халдваргүйтгэж бүртгэх.

7.2. Халдварын голомтоос гарах зорчигч, тээврийн хэрэгслийг бүртгэж, зааварын дагуу халдваргүйтгэх.

7.3. Голомтын бүс дэх иргэдийн хүнс, бараа, хүн, мал эмнэлгийн эм тариа, багаж тоног төхөөрөмжийг тусгайлан бэлтгэсэн талбай /тавцан/-д сэлгүүлэн буулгах, ачихад хяналт тавих.

7.4. Хорио цээрийн дэглэм цуцласан өдөр халдварын голомтод үүрэг гүйцэтгэсэн нийт бие бүрэлдэхүүний хувцас, биеийн ил хэсэг, багаж, техник, тээврийн хэрэгслийн зорчих хэсгийн гадна тал, явах эд анги, тэвшийг халдваргүйтгэх.

Хээрийн мал эмнэлэг дэлгэн ажиллах
зааврын 1 дүгээр хавсралт

ХАЛДВАРЫН ГОЛОМТОД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ БҮЛЭГ,
ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ОРОН ТОО

№	Бүлгийн нэр	Хүний тоо	Шаардагдах			Ариутгалын байр	Тээврийн хэрэгсэл	Тайлбар
			гэр	платик /4x4/	майхан /4-6 хүний/			
1	Удирдлагын бүлэг	8	2	1	3	-	2	дарга-1, орлогч-1, байцаагч-2, холбоочин-1, тогооч-1, жолооч-2
2	Нарийн мэргэжлийн /Лаборатори/ бүлэг	35	3	2	5		1	дарга-1, малын эмч- 5, мал баригч-20, ариутгагч- 2 жолооч- 5, тогооч- 2
3	Шалган нэвтрүүлэх, халдваргүйтгэлийн бүлэг	26	12	4	6	2	3	дарга- 1 онцгой байдлын албаны- 6, цагдаагийн албаны- 2, бүртгэгч 2, ариутгагч - 8, галч- 4, жолооч- 3
4	Устгалын бүлэг	21	2	2	3		2	дарга-1, ачигч -16, буудагч-2, жолооч-2
4		90	19	9	17	2	8	-

Тайлбар: - Энэхүү хүснэгтээр гаргасан тоог нэг суманд гарсан халдварын голомтод

2 ээлжээр үүрэг гүйцэтгэх хүн, тээврийн хэрэгслийн жишгээр тооцсон болно.

- Тухайн газар нутгийн онцлог, байршил, өвчний тархалт зэргээс хамаарч үүрэг гүйцэтгэх хүн, тээврийн хэрэгслийн тоо өөр өөр байж болно.

Хээрийн мал эмнэлэг дэлгэн ажиллах
зааврын 2 дугаар хавсралт

ХЭЭРИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН МЭДЭЭ

.... оны ... сар ... өдөр
.... цаг ... минут

№

.....
..... газрын нэр

1. Мал, амьтны гоц халдвартөвчин гарсан аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэрт үүссэн цагийн байдал, бодит /өссөн дүнгээр/ хохирол.
2. Халдварын голомтын тархалтыг таслан зогсоох, голомтыг устгах хор уршгийг богино хугацаанд арилгах талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үр дүн /бичмэл хэлбэрээр, зураг хавсаргах/.
3. Халдварт өвчинтэй тэмцэх явцад гарсан ололт, дутагдал, тохиолдож буй хүндрэл, бэрхшээл тэдгээрийг шийдвэрлэх арга зам /бичмэл хэлбэрээр/.
4. Хээрийн мал эмнэлгийн үндсэн чиг үүргийн хүрээнд хийсэн ажлын эцсийн тайлан, дүгнэлт, санал.
5. Байр зүйн болон аймаг, нийслэл, сум, дүүргийн бүдүүвч зураг.

Гарын үсэг

Хээрийн мал эмнэлэг дэлгэн ажиллах
зааврын 3 дугаар хавсралт

МАЛ, АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТӨВЧНИЙХОНОГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ

.... оны ... сар ... өдрийн дугаар цагийн байдлаар

№	Асуулт		Мэдээний ялгаа		Тайлбар	
			Урд өдрийн	Дараа өдрийн		
1	Үүрэг гүйцэтгэж байгаа бүгд хүн					
2	Халдварын голомтод байгаа	Өрхийн тоо				
		Бүгд хүн				
		Эр	0-17хүртлэх настай			
			18 нас ба түүнээс дээш			
Эм	0-17 хүртлэх настай					
	18 нас ба түүнээс дээш					
3	Харуул хамгаалалтад үүрэг гүйцэтгэсэн	Онцгой байдлын албан хаагчийн тоо				
		Иргэдийн тоо				
		Авто болон ердийн хөсөг, холбооны хэрэгслийн тоо	Автомашин			
			Мотоцикл			
Ердийн хөсөг						
		Холбооны хэрэгсэл				
4	Халдварын голомтод ашиглагдаж байгаа холбооны хэрэгслийн тоо/загвар					
5	Үзлэгт хамрагдсан өрх, мал, тэжээвэр амьтдын тоо	Өрхийн тоо				
		Бүгд мал				
		Үүнээс	Тэмээ			
			Адуу			
			Үхэр			
			Хонь			
Ямаа						
		Нохой г. м.				

6	Голомтод байгаа, мал, тэжээвэр амьтдын тоо	Үүнээс	Тэмээ				
			Адуу				
			Үхэр				
			Хонь				
			Ямаа				
			Нохой г. м.				
7	Өвчний ил шинж тэмдэгтэй тусгаарлагдсан, мал, тэжээвэр амьтдын тоо	Бүгд мал					
		Үүнээс	Тэмээ				
			Адуу				
			Үхэр				
			Хонь				
			Ямаа				
			Нохой г. м.				
8	Зориудаар устгасан, мал, тэжээвэр амьтдын тоо	Бүгд мал					
		Үүнээс	Тэмээ				
			Адуу				
			Үхэр				
			Хонь				
			Ямаа				
			Нохой г. м.				
9	Вакцинд хамрагдсан мал, тэжээвэр амьтдын тоо	Бүгд мал					
		Үүнээс	Тэмээ				
			Адуу				
			Үхэр				
			Хонь				
			Ямаа				
			Нохой г. м.				
10	Өвчнөөр хорогдсон мал, тэжээвэр амьтдын тоо	Бүгд мал					
		Үүнээс	Тэмээ				
			Адуу				
			Үхэр				
			Хонь				
			Ямаа				
			Нохой г. м.				
11	Халдваргүйтгэлд хамрагдсан	Зорчигчдын тоо					
		Тээврийн хэрэгслийн тоо					
		Хашаа хороо/ өтөг бууц /м.куб/					
		Малын тоног хэрэгслийн тоо					
		Худаг, уст цэгийн газрын өнгөн хэсгийн талбай /м ³ /					
		Хот айл, өрхийн тоо					
		Бусад объектийн тоо/ хэмжээ					
12	Үзлэг, вакцинжуулалтад ажилласан бүлэг, хэсэг, хүн, техникийн тоо						
13	Халдварын голомтод ажиллаж байгаа малын эмч, туслах ажилтны тоо						

14	Нөөц вакцины хэмжээ (л/тун)			
15	Ухаж бэлтгэсэн нүх (тоо/хэмжээ),газрын солбилцол (уртраг, өргөрөг)			
16	Устгасан сэг, зэмийн тоо			

ДҮГНЭЛТ:

САНАЛ:

Гарын үсэг

Нэгтгэсэн:

.....
/албан тушаалтан/нэр/

Жич: Мэдээг өссөн дүнгээр өгч, хүлээн авч байна.

Хээрийн мал эмнэлэг дэлгэн ажиллах
зааврын 4 дүгээр хавсралт

СУМ, ДҮҮРГИЙН ХҮН АМ, МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН СУДАЛГАА

№	Баг, хорооны нэр	Өрхийн тоо	Хүн амын тоо	Бүгд мал /тоо/	Үүнээс					Тэжээвэр амьтны тоо
					Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	

Гарын үсэг

..... СУМ, ДҮҮРГИЙН ХАЛДВАРЫН ГОЛОМТОДБАЙГАА АЙЛ, ӨРХИЙН
МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО

№	Баг, хорооны нэр	Айл, өрхийн тоо	Хүн амын тоо	Бүгд мал /тоо/	Үүнээс					Тэжээвэр амьтаны тоо
					Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	

Гарын үсэг

.....СУМ, ДҮҮРГИЙН ӨВЧНӨӨР ӨВЧИЛСӨН МАЛ,
ТЭЖЭЭВЭР АМЬТНЫГ ЗОРИУДААР УСТГАСАН ТУХАЙ МЭДЭЭ

№	Малчны овог, нэр	Баг, хорооныдугаар /нэр/	Бүгд мал /тоо/	Үүнээс					Тэжээвэр амьтны тоо
				Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	

Гарын үсэг

.....СУМ, ДҮҮРГИЙН ӨВЧНӨӨР ӨВЧИЛСӨН МАЛ, ТЭЖЭЭВЭР
АМЬТДЫГ УСТГАХ НҮХНИЙ БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, БАГТААМЖ

№	Баг, хорооны нэр	Устгал хийсэн газрын нэр	Солбилцол		Бэлтгэсэн нүх		Устгасан мал, амьтнытоо	Халдваргүй-жүүлсэн талбай (м ²)	Зарцуулсан химийн бодис(кг-р)	
			Уртраг	Өргөрөг	Тоо	Багтаамж			Формалин	Хлорын шохой

Гарын үсэг

ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТИЙН БОДИС УУСМАЛЫН ЗАРЦУУЛАЛТЫН ТООЦОО

№	Сум, дүүрэг, баг, хороо, газрын нэр	Хот айл/ өрх		Хашаа, хороо		Өтөг, бууц		Худаг		Зарцуулсан химийн бодис (кг- р)	
		тоо	талбай (м ²)	тоо	талбай (м ²)	тоо	талбай (м ²)	тоо	талбай (м ²)	Формалин	Хлорын шохой

Гарын үсэг

ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ БАЙРНЫТОМИЛГООТБҮРЭЛДЭХҮҮНИЙ БҮРТГЭЛ, СУДАЛГАА

№	Баг, хорооны нэр	Бүгд	Байнгын болон хөдөлгөөнт эргүүлийн төрөл						Тайлбар
			Онцгой байдлын албаны		Цагдаагийн		Энгийн		
			Офицер	Ахлагч	Офицер	Ахлагч	Төр, захиргааны ажилтан	Иргэд	

Гарын үсэг

**ХАЛДВАРЫН ГОЛОМТЫГ УСТГАХАД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭСЭН ХҮН,
ТЕХНИК ХЭРЭГСЛИЙНБҮРТГЭЛ**

№	Байгууллагын нэр	Хүний тоо	Тусгай зориулалтын техник					Авто - машин		Мотоцикл	Ердийн хөсөг	Багаж хэрэгсэл				Тайлбар
			Инженер -ийн		Химийн			Суудлын	Ачааны			Автомакс	Мананцар-жуулагч	Хүрз, лоом	бусад	
			Экскаватор	Трактор	Эмнэлэг ариутгалын автомашин /ДДА- 3-Б/	Халдваргүйт -гэлийн автомашин /АРС, ДУК/										

Гарын үсэг

Хээрийн мал эмнэлэг дэлгэн ажиллах
зааврын 5 дугаар хавсралт

ШААРДЛАГАТАЙ МАТЕРИАЛЫН ТООЦОО

№	Нэр, төрөл	Хэмжих нэгж
Нэг. Ажлын хувцас		
1	Ажлын хүрэм	1 хүнд 2-3 удаа сольж хэрэглэхээр тооцох
2	Ажлын өмд	
3	Хүрэмний дотор	
4	Ажлын гутал	
5	Бээлий	
6	Амны хаалт /N95/	
7	Нүдний шил /хуванцар/	
Хоёр. Химийн бодис		
8	Формалины уусмал	

9	Хлорын шохой	Хэрэглэгдэх талбайн хэмжээнээс хамаарч олгох
10	Виркон	
11	Идэмхий натри	
Гурав. Модон материал		
12	2 см-ийн зузаантай банз	2.5метр х 28ширхэг = 70 метр
13	3 см-ийн зузаантай банз	
14	Шургааг	
Дөрөв. Бусад материал		
15	Автомакс /1 бүлэгт 3 ширхэг/	6 ширхэг
16	Гарах, орох тэмдэглэгээ	4 ширхэг
17	Таних тэмдэг	Анхааруулах, халдварын голомт, хязгаарлалтын бүс, хяналтын бүс, сэрэмжлүүлгийн самбар тус бүр 2 ширхэг
18	Хүрз, лоом, жоотуу	Хүний тоогоор
19	Алх, сүх	3 хүний дунд 1 байх
20	Хадаас	5 килограм
21	Төмөр утас	50 метр
22	Өргөст тор	70-80 метр
23	Уяа	700-800 метр

Жич: - Ажлын /хөдөлмөр хамгаалалын/ хувцас нь хүйтний, дулааны улирлынх байна.
- Ажиллагсад хөдөлмөр хамгааллын хувцаснаас гадна өвчтэй мал, амьтанд үзлэг хийх тохиолдол бүрд нэг удаагийнхувцас, бээлий, амны хаалт хэрэглэнэ.